

**“Малын чанар сайжруулах хөтөлбөр”-ийн хүрээнд
2006 оноос 2007 оны 3 дугаар улирал хүртэлх хугацаанд
хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд хийсэн
хяналт-шинжилгээ үнэлгээний дүн**

2007.11.20

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Малын чанар сайжруулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид уг хөтөлбөрийн хүрээнд хийх ажлыг эрчимжүүлэн үр өгөөжийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн Газрын 2006 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 51 дугаар тогтоолоор батлагдсан *“Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”*-ыг арга зүйн үндэс болгов.

Хөтөлбөрийн хүрээнд 2006, 2007 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг хүлээн авч уншиж судлаад хөтөлбөр эхлэх үеийн суурь үзүүлэлттэй харьцуулан, дүн шинжилгээ хийсэн.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний үнэлгээ

Монгол Улсын Засгийн Газрын 2006 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 93 дугаар тогтоолоор батлагдсан уг хөтөлбөр нь дараахь үе шатаар хэрэгжинэ.

- Эхний үе шат 2006-2008 он
- Хоёр дахь үе шат 2008-2012 он
- Гурав дахь үе шат 2012-2015 он

Хөтөлбөрийн эрхэм зорилго нь мэргэжлийн албадын чадавхийг бэхжүүлэх замаар малын чанарыг сайжруулах, удмын санг хамгаалах, мал үржлийн ажилд дэвшилтэт арга, технологи нэвтрүүлэх явдал юм. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд хэрэгжүүлсэн арга хэмжээг зорилт тус бүрээр доор тольлуулж байна.

1. Цөм сүргийг баталгаажуулан бүртгэлжүүлж, үржил ашиг шимийн мэдээллийн сан, сүлжээ бий болгох зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил

ХХААЯ, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн. Улсын мэргэжлийн хяналтын газартай хамтран Монгол Улсад үржүүлж байгаа баталгаажсан үүлдэр, омгийн малыг нэгдсэн бүртгэлтэй болгох, ашиглах бүс нутгийг тогтоох журам болон Үржлийн мал бойжуулж борлуулах журам, Хээлтүүлэгч малын тохироог шинэчлэх зэрэг асуудлыг боловсруулж МААЭШХ-ийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжүүлсэн бөгөөд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа.

Энэ онд улсын хэмжээнд нийт 6045.4 мянган малд үзлэг ангилалт хийж цөм сүргийг бүрдүүлэх, хээлтүүлэгч малыг шинээр нөхөн тавих баталгаажуулах ажлыг зохион байгуулав. Орон нутгаас ирүүлсэн урьдчилсан дүн мэдээгээр нийт **327.7** мянган хээлтүүлэгч үзлэгт хамрагдаж 38,5 мянган хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьсан байна.

Хээлтүүлэгч малд үзлэг хийсэн дүн

| Үзүүлэлт | Үзпэгт хамрагдсан /тол/ | Жишигт тэнцсэн /хувь/ | Шинээр нөхөн тавьсан /тол/ |
|-------------|----------------------------|--------------------------|-------------------------------|
| Буур | 3426 | 89.7 | 420 |
| Азрага | 75606 | 95.1 | 1711 |
| Бух | 29895 | 89.0 | 2454 |
| Хуц | 106138 | 98.4 | 16837 |
| Ухна | 112668 | 92.7 | 17039 |
| Бүгд | 327733 | 92.9 | 38461 |

Ангилалт явуулсан дүн

| Үзүүлэлт | Ангилалтанд орсон /мян.тол/ | Бүртгэлд авсан цөм сүрэг /мян.тол/ | Үржүүлж байгаа | |
|-------------|-----------------------------------|--|----------------|------------------------------|
| | | | Иргэн | Аж ахуйн нэгж байгууллага |
| Хонь | 3036.4 | 392.8 | 2009 | 37 |
| ямаа | 3009.0 | 355.5 | 1970 | 25 |
| Бүгд | 6045.4 | 748.33 | 3979 | 62 |

Энэ онд мал бүртгэлжүүлэлтийн асуудлаар БНЧех улсад 400.0 мян долларын төсөвт өртөг бүхий төслийг хэрэгжүүлэхээр санал болгосон бөгөөд Чехийн засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд санхүүжүүлэхээр шийдвэрлэж төслийг хэрэгжүүлэх ажлын бэлтгэлийг хангаж байна. Энэ төслийн хүрээнд төвийн бүсийн аймгуудын малыг ээмэгжүүлэн бүртгэлжүүлэх бөгөөд энэ чиглэлээр ажиллаж байгаа 200 гаруй мэргэжилтнүүдийг мал бүртгэлжүүлэх чиглэлээр сургаж бэлтгэх юм.

Мөн Европын холбооноос манай яамны чиглэлээр хэрэгжих төсөлд мал бүртгэлжүүлэх талаар тодорхой асуудал тусгагдсан бөгөөд энэ төсөл хэрэгжих үед хоёр төслийг хооронд нь уялдуулан зохион байгуулна. Ингэснээр малын ашиг шим, удам гарвалийг тодорхой болгох, мал аж ахуйн бүтээгдэхүүн, малын эрүүл мэндэд бүртгэлээр тавих хяналт сайжирна. Дээрх төслүүдийн хүрээнд малын ашиг шимийг бүртгэх мэдээллийн улсын нэгдсэн сан, сүлжээ бий болгох ажлын эхлэл суурь тавигдаж хэрэглэгчдийг мэдээллээр хангах боломж бүрдэх юм.

Нэгдүгээр зорилтын хүрээнд хүрэх шалгуур үзүүлэлтүүд

| Шалгуур үзүүлэлтүүд | | Суурь үзүүлэлт (2005 он) | 2006 онд хүрсэн түвшин | 2008 онд хүрэх түвшин |
|---|--------|--------------------------------|------------------------------|-----------------------------|
| Бүртгэлд авсан үүлдэр, цөм сүргийн тоо /мян.тол/ | | 917.0 | 748.33 | 1000.0 |
| Баталгаажуулсан хээлтүүлэгч /хувиар/ | | 80.2 | 92.9 | 90.0 |
| Бүртгэл мэдээллийн сан, сүлжээнд хамрагдсан нэгжийн тоо | | 0 | | 22 |
| Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо | Буур | 22 | 24 | 21 |
| | Азарга | 7 | 7 | 8 |
| | Бух | 28 | 27 | 26 |
| | Хуц | 53 | 60 | 45 |
| | Ухна | 51 | 60 | 45 |

Энэ оны урьдчилсан дүн мэдээгээр үзлэг, ангилалтанд хамрагдсан 106138 толгой хуцны 98,4 % жишигт тэнцэж нь хамгийн өндөр үзүүлэлттэй, 29895 толгой бухны 89,0 % нь жишигт тэнцэж хамгийн бага үзүүлэлттэй гарсан байна. Дундаж үзүүлэлт 92,9% байгаа

нь 2008 онд хүрэхээр төлөвлөсөн түвшингээс 2.9 %-аар дээгүүр байна. Хээлтэгч малын тохироог бүс нутгийн онцлог, ашиг шимийн чиглэлийг харгалзан шинэчлэх асуудлаар эцсийн шийд гараагүй байгаагийн зэрэгцээ 2007 оны нэгдсэн мэдээ гараагүй байгаа тул тоон үзүүлэлтээр илэрхийлэх боломжгүй байна.

Малд үзлэг, ангилалт хийж зарим нэгжүүдэд цөм сүргийг бүрдүүлсэн хэдий ч хэрхэн баталгаажуулж байгаа нь тодорхойгүй, үр дүн цаашид тогтвортой хадгалагдах байдал нь баталгаагүй байна. Мөн аймгийн цөм сүргийн үржлийн төвүүдийг бүртгэл мэдээллийн сан, сүлжээнд хамруулах бэлтгэл хангах зорилгоор 85,9 сая төгрөгийн өртөгтэй компьютер, мэдээллийн техник хэрэгслийг нийлүүлсэн боловч мэдээллийн сан бүрдүүлэх арга зүй, ур чадвар эзэмшүүлэх чиглэлээр мэргэжилтнүүдийг сургаж дадлагуулах, ажлыг зохион байгуулаагүй байна.

Нэгдүгээр зорилтын хүрээнд 6 багц үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр хөтөлбөрт тусгасан байгаа. 2006-2007 онд боловсруулан батлуулахаар төлөвлөсөн 3 баримт бичгийн анхан шатны хэлэлцүүлэгүүдийг хийж эцсийн шийдвэр гарган баталгаажуулах дээд шатны байгууллага болон мэргэжлийн байгууллагад өргөн барьжээ. Мөн хуваарилагдсан санхүүжилтын хүрээнд төлөвлөгдсөн арга хэмжээг зохион байгуулж эхний үр дүнгүүд гарч эхэлсэн байна. Харин баталгаажсан цөм сүрэг, жишигт тэнцсэн хээлтүүлэгчийн үржил, ашиг шимийн үзүүлэлтээр аймгийн түвшинд мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийгдэж эхлээгүй байна.

Энэ зорилтын үр дүнгийн үнэлгээ 65.0 % байна.

2. Малын удмын сангийн нөөцийг баяжуулах зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил

Цөм сүргийн үржлийн төвүүдэд үүлдэр, омгийн шилмэл мапыг сонгон үржүүлэх зорилтыг тавин ажиллаж байна. Одоогийн байдлаар цөм сүргийн үржлийн төвүүдэд 20,0 гаруй мянган мал байгаа бөгөөд энэ онд дундажаар 1.0 мянга орчим өсвөр хээлтэгчийг үржилд зориулан бойжуулж иргэн, аж ахуйн нэгжийн хэрэгцээнд нийлүүлэв.

Гадаадаас өндөр ашиг шимт үүлдрийн мал, тэдгээрийн үрийг импортлон үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглах зорилтыг тавин ажиллаж байна. Энэ арга хэмжээний хүрээнд БНХАУ-с цэвэр үүлдрийн сүүний чиглэлийн үхэр худалдан авах тендер зарлан хар тарлан үүлдрийн бух 5, гунж 15-ыг худалдан авсны зэрэгцээ ОХУ, Хятад, Канад, Куба улсаас арвин ашиг шимт малын 20.0 гаруй мянган тун үрийг импортлож үржлийн малын чанарыг сайжруулахад ашиглаж байна.

Гадаадаас импортлосон өндөр ашиг шимт хээлтүүлэгчийн үр

(тунгаар)

| Гүн хөлдөөсөн үр | Импортлосон улс | | | |
|------------------|-----------------|------|-------|-------|
| | ОХУ | Куба | Хятад | Канад |
| Бухны | 957 | Х | 10000 | 2800 |
| Хуцны | Х | Х | 4000 | Х |
| Ухны | Х | 5000 | Х | Х |
| Бүгд | 957 | 5000 | 14000 | 2800 |

Энэ онд давхардсан тоогоор 20 аймгийн 52 суманд 57 салбар ажиллаж нийт 10914 малыг зохиомол аргаар хээлтүүлээд байна. Энэ тоог өнгөрсөн онтой харьцуулахад зохиомолоор хээлтүүлсэн малын тоо 2300-аар нэмэгдсэн байна.

**Ажилласан зохиомол хээлтүүлгийн салбар,
зохиомолоор хээлтүүлсэн мал**

| Төрөл | Ажил-ласан салбар | Зохиомлоор хээлтүүлсэн мал | | | Хамрагдсан | |
|--------|-------------------|----------------------------|---------|---------|------------|-----|
| | | Үнээ | Эм хонь | Эм ямаа | Аймаг | Сум |
| Үхрийн | 32 | 2100 | | | 9 | 30 |
| Хонины | 18 | | 8200 | | 5 | 15 |
| Ямааны | 7 | | | 614 | 6 | 7 |
| Бүгд | 57 | 2100 | 8200 | 614 | 20 | 52 |

Монгол Улсад гадаадаас оруулах үржлийн мал, амьтан тэдгээрийн үр, хөврөл үрийн гарваль, үүлдэр, ашиг шимийн жишиг үзүүлэлт, шаардлагыг тогтоож мөрдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд энэ шаардлагыг Мал эмнэлгийн газартай хамтран боловсруулж хөдөө аж ахуйн стандартын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулахаар стандарт хэмжил зүйн газарт хүргүүлээд байна.

Тэмээ, цаа бугын тоо нилээд цөөрч байгаа асуудлыг онцгойлон анхаарч тэдгээрийг зохистой ашиглах, удмын санг нь сэргээх зорилгоор "Тэмээ" хөтөлбөрийг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн ба "Цаа бугын аж ахуйг сэргээн хөгжүүлэх, цаачин иргэдийн амьжиргааг сайжруулах хөтөлбөр"-ийг холбогдох яамдуудтай хамтран боловсруулж Засгийн газрын 155 дугаар тогтоолоор батлуулж хэрэгжилтийг зохион байгуулж байна. Энэ арга хэмжээний хүрээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг ХХАА-н сайдын 2007 оны 133-р тушаалаар батлуулаад байна. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар 2007-2008 онд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөг баталсан бөгөөд 12-р сард эхлэлтийн семинарыг зохион байгуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна.

Хоёрдугаар зорилтын хүрээнд хүрэх шалгуур үзүүлэлтүүд

| Шалгуур үзүүлэлтүүд | | Суурь үзүүлэлт (2005 он) | 2006 онд хүрсэн түвшин | 2008 онд хүрэх түвшин |
|---|-----------------------------------|--------------------------|------------------------|-----------------------|
| Мал үржлийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа эрх бүхий | Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн | 50 | 57 | 100 |
| | Үржлийн төв | 1 | | 6 |
| Үржилд зориулан бойжуулсан малын тоо /мян.тол/ | Хээлтүүлэгч | 146.0 | 1.0 | 175.2 |
| | Хээлтэгч | 255.3 | | 306.3 |
| Үйлдвэрлэсэн үржлийн бүтээгдэхүүний тоо | Үр | 9700 | | 20000 |
| | Хөврөл үр | 0 | | 200 |
| Гадаадаас авсан /тоо/ | Мал | 100 | 20 | 3000 |
| | Үр, хөврөл үр | 17400 | 22757 | 20000 |
| Нийт малд цэвэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн малын эзлэх хувь | | 8.4 | | 10.0 |

Мал үржлийн ажил үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд энэ чиглэлийн үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх үйл

ажиллагааг дэмжиж тэдгээрийн бүтэц үйл ажиллагааны стандартыг боловсруулсан нь хөтөлбөрийн үр дүнгийн тогтворжилтонд чухал ач холбогдолтой ажил болсон байна.

2006, 2007 онд үржилд зориулан бойжуулсан малын тоог тодорхой гаргаж мэдээллээгүй байна. Иймээс суурь үзүүлэлттэй харьцуулан дүгнэлт хийх боломжгүй байдалд хүргэж буйг дараагийн тайлан бичихдээ анхаарах хэрэгтэй байна.

Гадаадаас өндөр ашиг шимт мал болон тэдгээрийн үржлийн бүтээгдэхүүн оруулж ирэхэд анхаарлаа хандуулж ажилласаны зэрэгцээ дотоодод цөм сүрэг бүрдүүлэх, үржлийн хээлтүүлэгч бойжуулах, импортыг орлох үржлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх чиглэлийг дэмжиж 7 аймгийн цөм сүргийн үржлийн төвд 24,0 сая төгрөгийн санхүүжилт хийсэн боловч үр дүн нь хараахан мэдрэгдэж эхлээгүй байна.

Хоёрдугаар зорилтын хүрээнд 8 багц үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр хөтөлбөрт тусгасан байгаа. Тэдгээрээс 2 багц үйл ажиллагаа хараахан эхлээгүй байгаа хэдий ч 2006-2007 оны үйл ажиллагааны үр дүнд 3 багц үйл ажиллагааны эхний үр дүнгүүд гарч тогтворжих шатандаа орсон, 2 багц үйл ажиллагаа хэрэгжих эхлэлийн шатандаа орсон байна. Мөн нэг багц ажлын хүрээнд стандарчлалын баримт бичиг боловсруулагдан эцсийн шатандаа хэлэлцэгдэж байна. **Энэ зорилтын үр дүнгийн үнэлгээ 75.0 % байна.**

3. Малын чанар ашиг шимийг дээшлүүлэх, малчин өрхийн аж ахуйг эрсдэлээс хамгаалах эдийн засаг, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил

"Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулах ажлын хэсэг ХХАА-н сайдын тушаалаар томилогдон ажиллаж, уг хуулийн төсөл УИХ-аар хэлэлцэгдэн батлагдсан.

Хадлан тэжээлийн хэмжээг нэмэгдүүлж бэлчээр нутгаа зохистой ашиглах байгалийн болзошгүй эрсдэлээс мал сүргээ хамгаалах зорилгоор "Малын тэжээл" хөтөлбөрийг боловсруулж ЗГ-ын 2007 оны 283 дугаар тогтоолыг батлуулаад байна. Мөн малын тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуйн нэгжид 98,0 сая төгрөгийн, бүрэн найрлагат тэжээлийн үйлдвэрлэл эрхэлдэг 2 аж ахуйн нэгжид 38,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Ингэснээр тэжээлийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх нөхцөл сайжрах бололцоог хангаж өгсөн. Цаашид үхэр хонины тэжээлийн үйлдвэр 5, тэжээлийн олон наст ургамлын үр үржүүлэх аж ахуй 3 бий болох юм.

Гуравдугаар зорилтын хүрээнд хүрэх шалгуур үзүүлэлтүүд

| Шалгуур үзүүлэлтүүд | | Суурь үзүүлэлт (2005 он) | 2007 онд хүрсэн түвшин | 2008 онд хүрэх түвшин |
|---|---------------|--------------------------|------------------------|-----------------------|
| Шинээр боловсруулсан болон нэмэлт өөрчлөлт оруулсан эрх зүйн баримт бичгийн тоо | | 4 | 3 | 3 |
| Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/ | | 140.0 | 399.4 | 1995.5 |
| Гадаадын болон олон улсын төсөл, хөтөлбөрт хамрагдсан байдал, санхүүжилт | Тоо | 3 | 4 | 4 |
| | мян ам.доллар | 200.0 | | 300.0 |
| Тэжээлийн жижиг дунд үйлдвэр | | 0 | 6 | 2 |
| Тэжээлийн болон олон наст ургамлын үр үржүүлэх аж ахуй | | 0 | 2 | 2 |

Хөтөлбөрийн эхний үе шат хэрэгжиж байгаа тул Малын чанар ашиг шимийг дээшлүүлэх, малчин өрхийн аж ахуйг эрсдэлээс хамгаалах эрх зүйн таатай орчин бүрдүүлэх чиглэлд ихээхэн анхаарлаа хандуулж ажиллан хангалттай үр дүнд хүрч чаджээ. Мөн гадаадын болон олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгийг авах талаар хүчин чармайлт гаргаж ажилласаны үр дүнд зарим нааштай шийдвэрүүд гарч үр дүн цаашид хадгалагдах хандлага бий болсон байна.

Хөтөлбөрийн үйл ажиллагааг гадаад орон, олон улсын байгууллагын шугамаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан зохион байгуулахад онцгойлон анхаарч ажилласаны үр дүнд Булган, Архангай, Хөвсгөл, Хэнтий аймгийн цөм сүргийн үржлийн төвийг бэхжүүлэх чиглэлээр Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн газартай, Төвийн бүсийн аймгуудын малыг бүртгэлжүүлэх чиглэлээр БНЧех улстай, Сүүний үхрийн үржлийн ажлыг сайжруулах чиглэлээр Дэлхийн хүнс хөдөө аж ахуйн байгууллагатай, Хонины хөврөл үрийг шилжүүлэн суулгах чиглэлээр Урагвай улстай тус тус хамтран ажиллаж төсөл хэрэгжүүлэхээр болоод байна.

Тэжээл үйлдвэрлэгчид болон олон наст ургамлын үр үйлдвэрлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор олгосон 168,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн үр дүн ямар байгаа талаар тайланд тодорхой асуудал тусгагдаагүй байна.

Гуравдугаар зорилтын хүрээнд 12 багц үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр хөтөлбөрт тусгасан байгаа. Тэдгээрээс 2 багц үйл ажиллагаа хараахан эхлээгүй байгаа хэдий ч 2006-2007 оны үйл ажиллагааны үр дүнд 3 багц үйл ажиллагааны эхний үр дүнгүүд гарч тогтворжих шатандаа орж, 2 багц үйл ажиллагаа хэрэгжих эхлэлийн шатандаа орсон байна. Мөн нэг багц ажлын хүрээнд стандарчлалын баримт бичиг боловсруулагдан эцсийн шатандаа хэлэлцэгдэж байна. **Энэ зорилтын үр дүнгийн үнэлгээ 90.0 % байна.**

4. Мал үржлийн ажил үйлчилгээ эрхлэх иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн чадавхийг дээшлүүлж, үр дүнг сайжруулах зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил

Мал үржлийн ажил, үйлчилгээг мэргэжлийн түвшинд эрхэлж байгаа зарим нэгжүүдийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг боловсруулан холбогдох газруудаар хэлэлцүүлэн баталгаажуулав. Энэ арга хэмжээний хүрээнд Малын удмын сангийн үндэсний төв, Цөм сүргийн үржлийн төв, Зохиомол хээлтүүлгийн салбаруудын стандартууд боловсрогдсон болно.

Мал аж ахуйн хүрээлэн, Улсын мэргэжлийн хяналтын газартай хамтран Үржпийн мал бойжуулж борлуулах журам, Мал сүргийг үржүүлэх бүсийн чиглэл, хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироог малын төрөл, ашиг шимийн чиглэл, нийлүүлгийн аргатай уялдуулан шинэчлэн боловсруулж, холбогдох газруудын саналыг авч, ХХАА-н сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болжээ.

Малыг шилэх, тохируулан сонгох, үр төлийн чанараар нь үнэлэх мэргэшсэн шинжээч мэргэжилтэн бэлтгэх сургалтыг тусгай хөтөлбөрөөр ХААИС-тай гэрээ байгуулан 2 удаа зохион байгуулж нийт 30-аад хүнийг суралцуулав. Мөн зохиомол хээлтүүлгийн технологич бэлтгэх сургалтыг бог, бод малын гэсэн чиглэлээр 2 удаа зохион байгуулж нийт 56 хүнийг хамруулсан болно.

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд хүрэх шалгуур үзүүлэлтүүд

| Шалгуур үзүүлэлтүүд | | Суурь үзүүлэлт (2005 он) | 2007 онд хүрсэн түвшин | 2008 онд хүрэх түвшин |
|------------------------------|--|--------------------------|------------------------|-----------------------|
| Мэргэжилтний хангамж, чадамж | Мал үржлийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа мэргэжилтний тоо | 98 | | 150 |
| | Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан мэргэжилтний тоо | 50 | 88 | 200 |
| | Давтан сургалтанд хамрагдсан мэргэжилтний тоо | 120 | | 400 |
| Үйлчилгээний нэгжийн чадамж | Үржлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон малын ашиг шимийн гарц, чанар тодорхойлох лаборатори | 1 | | 5 |
| | Зохиомол хээлтүүлгийн салбарын тоо | 30 | 57 | 45 |
| | Тоног төхөөрөмжөөр хангагдсан хувь | 10.0 | | 30.0 |
| | Сүлжээнд холбогдсон үржлийн алба, үржил-селекцийн төв | 1 | | 5 |

Сум, аймгийн түвшинд болон үндэсний түвшинд ажиллах мэргэжилтний мэдлэг, чадварыг дээшлүүлж хүний нөөцийг бэхжүүлэх асуудлыг сайн зохион байгуулсан болох нь дээрх үзүүлэлтээс харагдаж байна.

Материаллаг нөөцийг дээшлүүлэх асуудал хөрөнгө мөнгө ихээхэн шаарддаг тул богино хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй байдаг. Одоогоор салбаруудыг тоног төхөөрөмжөөр хангах, үржлийн төвүүдийг сүлжээнд холбох ажил хийгдэж амжаагүй байна. Харин малын удмын сангийн үндэсний төв болон зарим аймгийн цөм сүргийн үржлийн төвүүдийг бэхжүүлэхэд анхаарч ажиллажээ. Энэхүү материаллаг баазыг түшиглэн зохиомол хээлтүүлгийн салбаруудад ажиллах мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах боломж бүрэлдэж бий болох ёстой. Энэ зорилтын хувьд хөтөлбөр хэрэгжих эхний жилд хүрвэл зохих үр дүндээ хүрсэн гэж үзэж болохоор байна.

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд 10 багц үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр хөтөлбөрт тусгасан байгаа. Тэдгээрээс ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө шаардлагатай 1 багц үйл ажиллагаанаас бусад нь хэрэгжиж эхэлсэн ба сум, аймаг, улсын түвшинд малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах гэх мэт зарим ажлууд тогтворжих шатандаа оржээ. Төрийн бус байгууллагаар зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх зохистой механизмыг олж хэрэгжүүлэх талаар анхаарах шаардлагатай байгаа нь харагдаж байна.
Энэ зорилтын үр дүнгийн үнэлгээ 95.0 % байна.

Дөрөв. Ерөнхий үнэлгээ

| Зорилтууд | Зардлын зориулалт | Зарцуулсан зардал /сая.төг/ | | Үр дүнгийн үнэлгээ |
|----------------|---------------------------------------|-----------------------------|------|--------------------|
| | | 1.5 | 87.4 | |
| 1. Цөм сүргийг | "Малын чанар сайжруулах хөтөлбөр"-ийн | 1.5 | 87.4 | 65.0 |

| | | | | |
|--|---|-------|-------|--------------|
| баталгаажуулан бүртгэлжүүлж, үржил ашиг шимийн мэдээллийн сан, сүлжээ бий болгох | эхлэлтийн семинар зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах | | | |
| | Аймгийн мал үржлийн алба, Цөм сүргийн үржлийн төвүүдэд иж бүрэн компьютер тоног төхөөрөмж, хувилагч машин худалдан авах | 85.9 | | |
| 2. Малын удмын сангийн нөөцийг баяжуулах | Үржлийн цөм сүргийн мал үржүүлж үржлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үржлийн аж ахуй бий болгоход үзүүлэх дэмжлэг /7 аймгийн цөм сүргийн үржлийн төвд/ | 24.0 | 52.0 | 75.0 |
| | "Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах" хөтөлбөрийг боловсруулах, сурталчилах | 2.0 | | |
| | Цөм сүргийг бүрдүүлэх хээлтүүлэгч бойжуулах иргэн аж ахуйн нэгжийн ирүүлсэн төсөлд | 26.0 | | |
| 3. Малын чанар ашиг шимийг дээшлүүлэх, малчин өрхийн аж ахуйг эрсдэлээс хамгаалах эдийн засаг, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх | "Малын тэжээл" хөтөлбөр батлуулсан. Малын тэжээлийн үйлдвэрлэл эрхлэх, олон наст ургамлын үр үржүүлэх аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. | | | 90.0 |
| 4. Мал үржлийн ажил үйлчилгээ эрхлэх иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн чадавхийг дээшлүүлж, үр дүнг сайжруулах | "Мал аж ахуйн хөгжил" мянган малчны улсын зөвлөлгөөн зохион байгуулах | 25.0 | 260.0 | 95.0 |
| | Малыг шилэн, тохируулан сонгох, үр төлийнх нь чанараар үнэлэх шинжээч мэр-гэжилтэн бэлтгэх сургалт зохион байгуулах | 2.0 | | |
| | 13 аймгийн Цөм сүргийн үржлийн төвүүдэд бага даацын "Forland" маркийн ачааны автомашин, лабораторийн тоног төхөөрөмж болон үржлийн ажил, үйлчилгээний багаж, хэрэгсэл худалдан авах | 130.0 | | |
| | Малын удмын сангийн үндэсний төвийн лабораторийн барилга, бухны байрыг сэргээн засварлах | 88.0 | | |
| | Үржлийн шилмэл малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж гойд ашиг шимт мал шалгаруулах | 15.0 | | |
| Ерөнхий дундаж үнэлгээ | | | | 81.25 |

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн үнэлгээний дундаж 81,25 байгаа тул уг хөтөлбөрийг 2006-2007 онд **"Хангалттай"** үнэлгээтэй хэрэгжсэн гэж дүгнэж байна.

Тав. Дүгнэлт

1. Мал үржлийн ажил үйлчилгээ эрхэлж байгаа иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн ажил нь хамгийн бага зардал зарцуулсан хамгийн үр дүнтэй ажил болсон байна.
2. Мал үржлийн ажил үйлчилгээ эрхлэх иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажилласаны зэрэгцээ сумын түвшинд ажиллах мэргэжилтний мэргэжлийн үйлчилгээний санхүүжүүлтыг дэмжих хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн байна.

Зургаа. Цаашид анхаарах асуудал, санал, зөвлөмж

- Хөтөлбөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлтэнд тусгагдсан мэдээллийг иж бүрэн гаргаж, тайлагнах хариуцлагыг сайжруулахад анхаарч ажиллах
- Үржлийн төвүүдэд олгосон компьютеруудыг шаардлагатай программ хангамжаар хангаж, мэдээллийн бааз үүсгэх аргачлалд мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулан компьютер, техник хэрэгсэлийн ашиглалтыг сайжруулах
- Иргэд, аж ахуйн нэгжийн хэрэгцээнд нийлүүлэх үржлийн бүтээгдэхүүний тодорхой хувийг өөрийн оронд үйлдвэрлэх чадавхийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

МХШҮГ-ын мэргэжилтэн

С.Дивангар

Танилцаж зөвшөөрсөн:

МХШҮГ-ын дарга

Д.Бат-Эрдэнэ